



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 1150

Алтанбулаг

Г 2022 оныг “Бүтээн байгуулалт-Нийгмийн хөгжлийг дэмжих жил” болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн A/01 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2022 оныг “Бүтээн байгуулалт- Нийгмийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласугай.

2. Зарласан жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх шатны төр төсвийн байгууллагагүйд зарласан жилтэй холбогдуулан салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээндээ хувийн хэвшил болон иргэдийг идэвх санаачилгатай оролцохыг уриалж захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг төр, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч наарт үүрэг болгосугай.

4. Зарласан жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Янжиндулам), иргэд олон нийтэд мэдээлж, сурталчилж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Д.Амартувшин) наарт даалгасугай.



Н.ОТГОНЦОГТ